2015 оны 08 сарын 13 өдөр дугаар А/667 Улаанбаатар хот

Журам батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ын “а”, 29.2 дахь хэсэг, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2014 оны “Ухаалаг Улаанбаатар хөтөлбөр батлах тухай” 16/11 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХнь:

1. “Улаанбаатар хотын теле хяналтын нэгдсэн системийг төлөвлөх, зохион байгуулах, мэдээллийг ашиглах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Батлагдсан журмыг байгууллагынхаа үйл ажиллагаанд хэрэгжүүлж ажиллахыг холбогдох нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

3. Журмыг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж, нийслэлийн эдийн засаг, нийгмийн зорилт, төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд жил бүр тусган ажиллаж, биелэлтийг жил бүрийн 6 болон 12 дугаар сард багтаан Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Б.Бадрал/-нд тайлагнаж байхыг Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагын удирдлагуудад үүрэг болгосугай.

4. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба /Б.Бадрал/-нд даалгасугай.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГА
БӨГӨӨД УЛААНБААТАР ХОТЫН
ЗАХИРАГЧ Э.БАТ-ҮҮЛ

Нийслэлийн Засаг даргын 2015 оны
08 дугаар сарын 13-ны өдрийн
А/667 дугаар захирамжийн
хавсралт

УЛААНБААТАР ХОТЫН ТЕЛЕ ХЯНАЛТЫН НЭГДСЭН СИСТЕМИЙГ ТӨЛӨВЛӨХ, ЗОХИОН БАЙГУУЛАХ, МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэ журмын зорилго нь Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт ашиглаж байгаа, цаашид хэрэгжүүлэх хяналтын камерыг нэгдсэн системд оруулж, мэдээллийг өргөн хүрээнд зохистой ашиглахад оршино.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын Үндсэн хууль, Төрийн нууцын тухай, Хувь хүний нууцын тухай, Байгууллагын нууцын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, стандартуудыг мөрдлөг болгоно.

1.3. Нийслэлийн нутгийн захиргааны байгууллагууд улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар хийгдсэн ба хийгдэх хяналтын камерын систем болон мэдээлэл ашиглах харилцааг энэ журмаар зохицуулна.

1.4. Энэхүү журамд хэрэглэсэн дараах нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

1.4.1.“Хяналтын камер” гэж хянах зориулалтаар ашигладаг, аналоги болон тоон сүлжээнд холбогдсон, системийн хувьд эцсийн цэгт байрлах дүрс дуу бичих биет төхөөрөмжийг;

1.4.2 “Замын хөдөлгөөний хяналтын камер” гэж зөвхөн гудамж, зам дээрх тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хянаж, замын хөдөлгөөний дүрмийн тодорхой заалтыг зөрчсөн тохиолдол болон тээврийн хэрэгслийн улсын дугаарыг баримтжуулах зориулалт бүхий хяналтын камерыг;

1.4.3. “Нийтийн эзэмшлийн талбайн хяналтын камер” гэж нийтийн эзэмшил, олон нийтийн гудамж, талбай, түүнчлэн байгууллагын гэмт хэрэг, зөрчил, гамшиг ослоос урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, олж илрүүлэхэд ашиглах зориулалт бүхий хяналтын камерыг;

1.4.4. “Хяналтын камерын систем” гэжхяналтын камер, түүний мэдээллийг хүлээн авч буй дэлгэц, камерын мэдээллийг хадгалах, санах ой бүхий төхөөрөмж, суурь болон салбар сүлжээний төхөөрөмжүүд, цахилгаан тэжээлийн холболтын шугам болон нөөц тэжээлийн үүсгүүрийн төхөөрөмж, камерын удирдлагын системийн цогцыг;

1.4.5. “Хяналтын камерын мэдээлэл” гэж хяналтын камераас сүлжээгээр дамжин ирж байгаа видео болон фото дүрс бүхий бичлэгийг;

1.4.6. “Шилэн кабелийн сүлжээ” гэж бүх хяналтын камерийг хяналтын системтэй холбохын тулд оптик кабель ашигласан байх ба тухайн үүсгэсэн сүлжээг өргөтгөх бүрэн боломжтойгоор байгуулсан сүлжээг;

1.4.7. “Төрийн тусгай хяналтын камер” гэж гадаад дотоодын төрийн өндөр албан тушаалтны замын хөдөлгөөн, тэдгээрийн нийтийг хамарсан арга хэмжээнд

оролцох үеийн төрийн тусгай хамгаалалтыг зохион байгуулах, төрийн тусгай хамгаалалтад байхаар тогтоосон барилга, бусад зүйлийн аюулгүй байдлыг хангах зорилготой камерыг;

1.4.8. Төрийн тусгай хяналтын камерыг зөвхөн Төрийн тусгай хамгаалалтын газар ашиглах нөхцөлтэй байх ба тус журмын 10.1-д заасан байгууллагууд ашиглах тохиолдолд Төрийн тусгай хамгаалалтын газраас зөвшөөрөл авна.

ХОЁР.УЛААНБААТАР ХОТЫН НЭГДСЭН ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМИЙН ПРОГРАМ ХАНГАМЖИЙН ТЕХНИКИЙН ҮНДСЭН ШААРДЛАГА

2.1. Замын хөдөлгөөний телехяналтын системийн техникийн шаардлага:

Гудамж зам талбайд тавигдаж байгаа телехяналтын камер нь Монгол Улсын “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага /MNS 6423:2013/ стандарт”-д нийцэхээс гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.1.1. Тээврийн хэрэгсэл 125 км/ц болон түүнээс дээш хурдтай явахад улсын дугаарыг таньдаг байх;

2.1.2. Тээврийн хэрэгсэл жолоодож буй жолоочийн нүүр тод харагддаг байх;

2.1.3. Тээврийн хэрэгслийг улсын дугаараар нь явсан чиглэл, хурд хугацааг богино хугацаанд тодорхойлж, эрэн сурвалжлагдаж байгаа тээврийн хэрэгслийг илрүүлэндохио өгдөг байх;

2.1.4. Зөрчил бүрээр тээврийн хэрэгслийг улсын дугаараар болон эзэмшигчээр тус бүрт нь тайлан гардаг байх /гэрэл дохио, хурд гм/;

2.1.5. Дүрсний нягтаршил хамгийн багадаа HD 720пиксел байх;
2.1.6. Харанхуйд бичлэг хийх чадвартай байх;
2.1.7. Мэдээллийннууцлал аюулгүй байдлыг хангасан байх;
2.1.8. Дүрсний хоцрогдолгүй болон автомашины дугаарыг нэгээс илүүгүй секундад боловсруулдаг байх;

2.1.9. Хурд, гэрлэн дохио, 1 дүгээр эгнээ зэрэг замын хөдөлгөөний зөрчлийг бүртгэх тусгай зориулалтын байх;

2.1.10. 3 дугаар эгнээ авто замаар зорчих тээврийн хэрэгслийн эгнээ бүрийг зэрэг бүртгэх

2.1.11. Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль тогтоомж, бусад эрх зүйн актууд /хурд хэтрүүлсэн гэрэл дохио зөрчсөн, зогсолт зогсоолын журам гэх мэт/-ыг зөрчсөн зөрчлыг бүртгэж, мэдээлэх, боловсруулах боломжтой байх

2.2. Нийтийн эзэмшлийн зам, талбайнтелехяналтын системийн техникийн шаардлага:

Гудамж зам талбайд тавигдаж байгаа телехяналтын камер нь Монгол Улсын “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага /MNS 6423:2013/ стандарт”-д нийцэхээс гадна дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

2.2.1. Хүний царай зүс, гадаад дүр төрх, содон шинж тэмдгийг татаж томруулах боломжтой байх;
2.2.2. Харанхуйд бичлэг хийх чадвартай байх;

2.2.3. Дүрсний нягтаршил хамгийн багадаа HD 720 пиксел байх;

2.2.4. Мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангасан байх;

2.2.5. Дүрсний хоцрогдолгүй байх;

2.2.6. Шаардлагатай тохиолдолд эрэн сурвалжлагдаж байгаа хүнийг нүүр, биеийн хэмжээ зэрэг заасан өгөгдлөөр нь харьцуулан таньж богино хугацаанд тодорхойлон илрүүлж дохио өгдөг байх;

2.2.7. Иргэний гаргасан зөрчлийг зөрчил тус бүрээр тайлан гаргадаг байх /хулгай, дээрэм, танхай, хүн амь, хүчирхийлэл гм,/.

ГУРАВ. УЛААНБААТАР ХОТЫН НЭГДСЭН ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМД ХОЛБОГДОХ КАМЕРЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

3.1. Замын хөдөлгөөний теле хяналтын камерын техникийн үзүүлэлтэнэ журмын 2.1–д заасан шаардлагыг хангаж,системд холбогдох боломжтой, усны хамгаалалттай, газар хөдлөлтийн 8 баллд болон -40^{0}С-ээс +40^{0}С хэмд тэсвэртэй байх;

3.2. Нийтийн эзэмшлийн талбайн хяналтын камерын техникийн үзүүлэлт журмын 2.2 –д заасан шаардлагыг хангаж,системд холбогдох боломжтой усны хамгаалалттай, газар хөдлөлтийн 8 баллд болон -40^{0}С-ээс +40^{0}С хэмд тэсвэртэй байх;

3.3. Шон болон хананд суурилуулах, хувиарлах самбар нь IP-66 стандартыг хангасан байх;

3.4. Цахилгааны тэжээлийн кабель нь 2х2,5мм2 хөндлөн огтлолтой байх ба тоног төхөөрөмжүүд нь хувьсах 220в/240в, 50гц нэг-фазын цахилгаан тэжээлээр ажилладаг байх;

3.5. Хяналтын камерын тоолуур нь электрон байх;

3.6. Серверийн өрөөг тусад нь төлөвлөж өгөх;

3.7. Хяналт явуулах өрөө тасалгаа нь оператор сууж ажиллах нөхцөлийг хангасан зай талбайтай, агааржуулалтын системийг бүрэн шийдсэн байна.

3.8. Камерын төрлийг ангилах, зориулалт, стандартын шаардлага хангасан мэдээллийн баазын програм хангамж, техник хангамжийн доод хязгаар тогтоох, 5-аас дээш жил ажилласан камерыг шинэчлэх

3.9. Телехяналтын нэгдсэн болон дэд системүүд байгуулах, гудамж, зам талбайд телехяналтын камер тавьж ашиглах, системийн сүлжээ, телехяналтын удирдлагын төв, хяналтын цэг сонгох, нэгдсэн удирлагын систем байгуулах, ашиглахдаа Монгол улсын “Барилга, орон сууц, гудамж талбайд тавих хяналтын камер, Ерөнхий шаардлага /MNS 6423:2013/ стандарт”-ын шаардлагад нийцсэн байдлаар зохион байгуулна.

ДӨРӨВ. УЛААНБААТАР ХОТЫН НЭГДСЭН ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМД ХОЛБОГДОХ

4.1. Улс, нийслэл, гадаадын хөрөнгө оруулалт, концессийн гэрээ болон “Ухаалаг Улаанбаатар” хөтөлбөрийн хүрээнд нийслэлд суурилуулж буй замын хөдөлгөөний, нийтийн эзэмшлийн талбайн хяналтын болон тусгай зориулалтын камерыгУлаанбаатар хотын нэгдсэн хяналтын системд заавал холбоно.

4.2. Энэ журмын 4.1-т заасны дагуу камерыг Улаанбаатар хотын нэгдсэн хяналтын системд холбох тохиолдолд тухайн камерийн эзэмшигч нь ашиглалт, зориулалтад нийцсэн санах байгууламжийг /сервер/ байрлуулна.

ТАВ. УЛААНБААТАР ХОТЫН НЭГДСЭНТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМИЙН МЭДЭЭЛЛИЙН БААЗЫН ТЕХНИКИЙН ШААРДЛАГА

5.1. Улаанбаатар хотыннутаг дэвсгэрт тавигдсан телехяналтын системийн мэдээллийн нэгдсэн систем, өгөгдлийн сан нь “Нийслэлийн ДАТА төв”-д хадгалагдах бөгөөд шаарлагатай тохиолдолд системийн нөөц хувилбарыг “Үндэсний ДАТА төв” УТУГ-т байршуулна.

ЗУРГАА. ТЕХНИКИЙН НӨХЦӨЛ, ЗӨВШӨӨРӨЛ АВАХ

6.1. Улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжигдаж байгаа тохиолдолд дараах техникийн нөхцлийг захиалагч байгууллага нийслэлийн мэдээллийн технологийнгазраасавна. Үүнд:

6.1.1. Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын систем байгуулах техникийн нөхцөл;

6.1.2. Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын системд холбогдох камерын техникийн нөхцөл.

6.2. Улс, орон нутгийн төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжигдаж байгаа ажил гүйцэтгэгч байгууллага нь ажил эхлэхээс өмнө зураг төсвийн ажлыг хийж гүйцэтгэн нийслэлийн мэдээллийн технологийн газраар баталгаажуулсан байна.

ДОЛОО. УГСРАЛТ, СУУРИЛУУЛАЛТ

7.1. Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын систем байгуулах, холбогдох, мэдээлэл авах, холболт хийхэд нийслэлийн мэдээлэл, технологийн асуудал хариуцсан байгууллага, ТЕГ, Үндэсний дата төв хамтран боловсруулна.

7.2. Ажил гүйцэтгэгч байгууллага нь шилэн кабелийн сүлжээ үүсгэж байгаа тохиолдолд бирк тэмдэг тэмдэглэгээ тавьж шилэн кабель суурилуулах MNS 5209:2002 стандартыг мөрдөж ажиллана.

7.3. Ажил гүйцэтгэгч байгууллага нь камерыг тусгай зориулалтын шон болон гаран дээр суурилуулна.

7.4. Ажил гүйцэтгэгч байгууллага нь хяналтын камерын шон босгохдоо аянга зайлуулагч болон газардуулгын системд холбогдсон R<=4 ом эсэргүүцэлтэй байна. Газардуулгын эсэргүүцлийг эрх бүхий байгууллагаар хэмжүүлж баталгаажуулсан байх ба газардуулгын MNS 2361:1977 стандартын шаардлагыг хангаж ажиллана.

НАЙМ. ХЯНАЛТЫН КАМЕРЫН НЭГДСЭН БҮРТГЭЛ

8.1. Улсын төсөв, гадаадын хөрөнгө оруулалтаар санхүүжигдэж байгаа Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын системд холбогдох камерын бүртгэлийг захиалагч байгууллага хариуцах бөгөөд ажил хүлээн авах комисс камерыг хүлээн авсанаас хойш ажлын 5 хоногийн дотор нийслэлийн мэдээллийн технологийн газарт мэдэгдэж, хяналтын камерын нэгдсэн бүртгэлд бүртгүүлнэ.

8.2. Ажил дуусч комисст хүлээлгэн өгөхдөө Нийслэлийн мэдээллийн санд шилэн кабелийн болон цахилгааны трассын зургийг оруулна.

ЕС. АРЧИЛГАА, ҮЙЛЧИЛГЭЭ

9.1. Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын системийн програм хангамжийн арчилгаа, үйлчилгээг нийслэлийн мэдээллийн технологийнгазархариуцаж, шаардлагатай зардлыг тухайн оны төсөвт суулгуулан урсгал зардалдаа бүртгүүлнэ.

9.2. Замын хөдөлгөөний хяналтын камерын арчилгаа, үйлчилгээг Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв хариуцаж, Улаанбаатар хотын Захирагчийн Ажлын алба шаардлагатай зардлыг тухайн оны төсөвт суулгуулан урсгал зардалдаа бүртгүүлнэ.

9.3. Нийтийн эзэмшлийн талбайн хяналтын камерын арчилгаа, үйлчилгээг Нийслэлийн Шуурхай удирдлага зохицуулалтын төв хариуцаж, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба шаардлагатай зардлыг тухайн оны төсөвт суулгуулан урсгал зардалдаа бүртгүүлнэ.

9.4. Улаанбаатар хотын нэгдсэн теле хяналтын системийн мэдээллийн баазын арчилгаа, үйлчилгээг нийслэлийн мэдээллийн технологийн газар хариуцаж, шаардлагатай зардлыг тухайн оны төсөвт суулгуулан урсгал зардалдаа бүртгүүлнэ.

9.5. Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын систем, нийслэлийн өмчийн камерыг холбосон шилэн кабелийн найдвартай ажиллагаа, арчилгаа, үйлчилгээг нийслэлийн мэдээллийн технологийнгазар хариуцаж, шаардлагатай зардлыг тухайн оны төсөвт суулгуулан урсгал зардалдаа бүртгүүлнэ.

9.6. Камерыг 5-с дээш жил ашигласан тохиолдолд заавал шинэчлэх шаардлагатай

АРАВ. УЛААНБААТАР ХОТЫН НЭГДСЭН ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМИЙН МЭДЭЭЛЛИЙГ АШИГЛАХ,СОЛИЛЦОХ

10.1. Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын системд дараах байгууллагууд холбогдож, суурилагдсан бүх камерыг ажиглах эрхтэй. Үүнд:

-Тагнуулын ерөнхий газар;

-Цагдаагийн ерөнхий газар болон түүний харьяа алба, газар, нутаг дэвсгэрийн цагдаагийн газар, хэлтэс;

-Нийслэлийн Мэдээллийн технологийн газар;

-Нийслэлийн Онцгой байдлын газар;

-Яаралтай тусламжийн төв;

-Нийслэлийн Шуурхай удирдлага зохицуулалтын төв;

-Нийслэлийн Замын хөдөлгөөний удирдлагын төв;

10.2. Тус журмын 10.1-д зааснаас бусад байгууллага Улаанбаатар хотын нэгдсэнтелехяналтын системээс гэмт хэрэг, зөрчилтэй холбоотой мэдээллээс бусад мэдээлэл авах тохиолдолд ДАТА эзэмшигч байгууллага болон нийслэлийн мэдээллийн технологийнгазрынэрх бүхий албан тушаалтнаас зөвшөөрөл авна.

10.3 Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын системийн мэдээллийг байгууллагууд хоорондоо солилцох тохиолдолд өөрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнаас албан бичгээр зөвшөөрөл авна.

10.4 Камерын бичлэгт үлдсэн бичлэгийг тухайн цагдаа, замын цагдаагийн газрын цаасан хэрэг хадгалах дүрэм журмын дагуу төрөлжүүлж, нягтлан шалгаж, ач холбогдлоор нь хадгалах хугацаа/байнга, түр/-г тогтооно

АРВАН НЭГ. УЛААНБААТАР ХОТЫН НЭГДСЭН ТЕЛЕ ХЯНАЛТЫН СИСТЕМД НЭВТРЭХ

11.1. Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын системийгашиглагч байгууллага нь системд нэвтрэх эрх бүхий 1-2 албан хаагчийг томилно.

11.2. Системд нэвтрэхээр томилогдсон эрх бүхий албан хаагч нь нийслэлийн мэдээллийн технологийнгазраас зохион байгуулдаг тусгай сургалтад хамрагдаж, сертификат авсан байх шаардлагатай.

11.3. Системд нэвтрэхээр томилогдсон эрх бүхий албан хаагчтай тухайн байгууллага нууц хадгалах тухай гэрээ байгуулж ажиллана.

11.4. Нийслэлийн Мэдээллийн технологийн газраас энэ журмын 11.3-т заасан гэрээг үндэслэн хандалтын эрх өгнө.

АРВАН ХОЁР. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

12.1.Техникийн ажилтны үйлдлээс болж хяналтын камерын системийн аюулгүй байдал алдагдах, мэдээллийн аюулгүй байдлын журам зөрчигдөж, байгууллагын үйл ажиллагаанд хохирол учруулсан ба эмзэг байдал үүсгэсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн хуулийн дагуу зөрчилд нь тохируулж хариуцлага ногдуулна.

12.2. Теле хяналтын системд нэвтрэх эрх бүхий ажилтан болон бусад техникийн ажилтан нь гэмт хэргийн талаарх мэдээллийг хууль бусаар устгах, хуулах, бусдад ашиглах зорилгоор зөвшөөрөлгүй өгсөн тохиолдолд нь тухайн үйлдлийг цагдаагийн байгууллагад шилжүүлж, шалгуулах арга хэмжээ авна.

12.3. Хяналтын камер хэрэглэгч нь мэргэжлийн байгууллагаас баталсан стандартын дагуу хяналтын камерын системийг суурилуулаагүй бол хариуцсан мэргэжилтэнд энэхүү журмын 12.1-д заасны дагуу хариуцлага хүлээлгэж, хяналтын системийг шинээр стандартын дагуу суурилуулахыг шаардана.

АРВАН ГУРАВ. МЭДЭЭЛЭЛ ХАДГАЛАХ, АРХИВЛАХ

13.1. Улаанбаатар хотын нэгдсэн телехяналтын системийн мэдээллийг 30 хоног хүртэл хугацаанд хадгална.

13.1.1. Гэмт хэрэгтэй холбоотой байж болзошгүй мэдээллийг 12 сар хүртэл хугацаанд хадгална.

13.1.2. Гэмт хэрэгтэй холбоотой мэдээллийг 18 сар хүртэл хугацаанд хадгална.

13.2. Тухайн байгууллага шаардлагатай гэж үзсэн нөхцөлд мэдээллийг компакт дискэнд хуулж архивт хадгална.

13.3. Камерын бичлэгт үлдсэн бичлэгийг тухайн цагдаа, замын цагдаагийн газрын цаасан хэрэг хадгалах дүрэм журмын дагуу бичлэгийг мөн адил төрөлжүүлж нягтлан шалгаж, ач холбогдлоор нь хадгалах хугацаа/байнга, түр/-г тогтооно.

13.4. Тухайн архивлах бичлэгийг багтаамжаас нь хамааран CD, DVD-нд бичлэг тус бүрээр нь хадгалана.

13.5. Архивын Ерөнхий газрын даргын 2014 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн "Кино, дуу, дүрсний баримтын хадгалалт, хамгаалалтын заавар батлах тухай" А/34 дүгээр тушаалыг үндэслэж тусгай төрлийн баримтыг архивлан, хадгална.

----ООО------